



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сум дахь сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/24/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342315 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

  
**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.19 № 55

талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган суман дахь сум дундын ойн ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган суман дахь сум дундын ойн ангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

006020117

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13,909,907.90</u></b>	<b><u>10,006,753.05</u></b>	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,495,876.90	10,006,753.05	
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4,400,449.80	4,400,449.80	
35110	Тусгай зориулалттай материал	4,400,449.80	4,400,449.80	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,095,427.10	5,606,303.25	
35410	Бичиг хэргийн материал	198,600.00	101,800.00	
35420	Аж ахуйн материал	6,428,816.00	5,077,816.00	
35440	Түлш, шатах тослох материал	448,011.10	426,687.25	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>50,896,551.24</u></b>	<b><u>41,600,776.00</u></b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	50,896,551.24	41,600,776.00	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	50,896,551.24	41,600,776.00	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,850,000.00	70,850,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,970,000.24)	(33,115,000.32)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,547,266.00	11,778,876.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,530,714.52)	(9,283,099.68)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,466,900.00	1,370,000.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>64,806,459.14</u></b>	<b><u>51,607,529.05</u></b>	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>64,806,459.14</u></b>	<b><u>51,607,529.05</u></b>	
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	64,806,459.14	51,607,529.05	
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	64,806,459.14	51,607,529.05	
51210	Өмнөх үеийн үр дүн	64,806,459.14	64,806,459.14	
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,198,930.09)	
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>64,806,459.14</u></b>	<b><u>51,607,529.05</u></b>	

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>99,415,815.80</b>	<b>62,097,679.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,032,215.80</b>	<b>20,280,479.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	49,032,215.80	20,280,479.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,032,215.80	20,280,479.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,751,265.00	18,110,479.00	

**Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,280,950.80	2,170,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>50,383,600.00</b>	<b>41,817,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,150,600.00</b>	<b>16,745,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,137,600.00	16,745,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>29,233,000.00</b>	<b>25,072,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,233,000.00	25,072,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>75,972,507.24</b>	<b>75,296,609.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>75,972,507.24</b>	<b>75,296,609.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>74,712,346.24</b>	<b>73,552,756.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>35,209,407.00</b>	<b>33,988,744.15</b>
210101	Үндсэн цалин	23,312,785.00	26,418,002.00
210102	Нэмэгдэл	935,639.00	6,602,509.15
210104	Урамшуулал	324,869.00	968,233.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,543,685.31</b>	<b>4,165,489.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,308,775.01	2,908,799.70
210202	Тэтгэмжийн даатгал	341,552.67	342,199.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	279,040.80	282,014.88
210204	Ажилгүйдлийн даатгал	50,400.59	68,399.12
210205	Эрүүл мэндийн даатгал	563,916.24	564,076.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,365,106.10</b>	<b>3,436,247.85</b>
210401	Бичиг хэрэг	400,990.00	641,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,545,015.10	2,262,063.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	419,101.00	532,334.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>949,660.00</b>	<b>1,174,000.00</b>
210604	Урсгал засвар	949,660.00	1,174,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>750,000.00</b>	<b>228,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	750,000.00	228,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,491,810.00</b>	<b>689,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,265,670.00	331,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,340.00	106,000.00

**Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,600.00	99,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,200.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,402,677.83</b>	<b>29,371,275.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,006,903.69	17,905,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,395,774.14	11,465,775.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,260,161.00</b>	<b>1,743,852.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>1,443,852.31</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,443,852.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>23,443,308.56</u></b>	<b><u>(13,198,930.09)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>23,443,308.56</u></b>	<b><u>(13,198,930.09)</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>70,329,065.00</u></b>	<b><u>62,341,710.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>19,958,465.00</u></b>	<b><u>20,524,510.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	19,958,465.00	20,524,510.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,751,265.00	18,110,479.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,751,265.00	18,110,479.00
120009	Бусад орлого	4,207,200.00	2,414,031.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>50,370,600.00</u></b>	<b><u>41,817,200.00</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,137,600.00	16,745,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,137,600.00	16,745,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29,233,000.00	25,072,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,233,000.00	25,072,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>70,329,065.00</u></b>	<b><u>62,341,710.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>70,329,065.00</u></b>	<b><u>62,341,710.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>69,068,904.00</u></b>	<b><u>60,597,857.69</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	34,884,538.00	33,988,744.15
210101	Үндсэн цалин	23,312,785.00	26,418,002.00
210102	Нэмэгдэл	935,639.00	6,602,509.15

Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210104	Урамшуулал		968,233.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,543,684.00	4,165,489.54
210201	Тэтгэврийн даатгал	3,308,775.00	2,908,799.70
210202	Тэтгэмжийн даатгал	341,553.00	342,199.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	279,040.00	282,014.88
210204	Ажилгүйдлийн даатгал	50,400.00	68,399.12
210205	Эрүүл мэндийн даатгал	563,916.00	564,076.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,100,640.00	3,109,524.00
210401	Бичиг хэрэг	336,600.00	336,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,344,939.00	2,240,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	419,101.00	532,334.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	771,399.00	793,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	771,399.00	793,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,008,600.00	694,000.00
210604	Урсгал засвар	1,008,600.00	694,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	750,000.00	228,000.00
210702	Дотоод албан томилолт	750,000.00	228,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,043,140.00	689,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,817,000.00	331,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,340.00	106,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,600.00	99,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	31,200.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,966,903.00	16,929,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,966,903.00	16,929,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,260,161.00</b>	<b>1,743,852.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	1,443,852.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,443,852.31

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	41,051,281.58		41,051,281.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	41,051,281.58	-	41,051,281.58
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	23,755,177.56		23,755,177.56
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	64,806,459.14	-	64,806,459.14
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	64,806,459.14	-	64,806,459.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	64,806,459.14	-	64,806,459.14
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,198,930.09)		(13,198,930.09)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	51,607,529.05	-	51,607,529.05

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	69693773.00	44730100.00	44152857.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	69693773.00	44730100.00	44152857.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	69393773.00	44430100.00	43852857.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	35209407.00	34221500.00	33988744.15
210101	Үндсэн цалин	0.00	23312785.00	24071700.00	26418002.00
210102	Нэмэгдэл	0.00	935639.00	10149800.00	6602509.15
210104	Урамшуулал	0.00	324869.00	0.00	968233.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	4543684.00	4277600.00	4165489.54
210201	Тэтгэврийн даатгал	0.00	3308775.00	2908800.00	2908799.70
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	341553.00	342200.00	342199.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	279040.00	273800.00	282014.88
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	50400.00	68400.00	68399.12
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	563916.00	684400.00	564076.22
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	3100640.00	3120800.00	3109524.00
210401	Бичиг хэрэг	0.00	336600.00	336600.00	336450.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	2344939.00	2251200.00	2240740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	419,101.00	533,000.00	532,334.00
2105	Нормативт зардал	-	771,399.00	801,000.00	793,300.00

Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	771,399.00	801,000.00	793,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,008,600.00	709,100.00	694,000.00
210604	Урсгал засвар	-	1,008,600.00	709,100.00	694,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	750,000.00	250,000.00	228,000.00
210702	Дотоод албан томилолт	-	750,000.00	250,000.00	228,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	6,043,140.00	802,600.00	689,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,817,000.00	445,000.00	331,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	108,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	95,340.00	106,000.00	106,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	99,600.00	99,600.00	99,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	31,200.00	44,000.00	44,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	17,966,903.00	247,500.00	184,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,966,903.00	247,500.00	184,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	300,000.00	300,000.00	300,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	300,000.00	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00	300,000.00	300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	44,984,265.00	44,730,400.00	25,072,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	29,233,000.00	44,730,400.00	25,072,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	29,233,000.00	44,730,400.00	25,072,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	-	9.00	9.00
620001	Удирдах ажилтан	-	-	5.00	5.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	1.00	1.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	1.00	1.00
620004	Гэрээт ажилтан	-	-	2.00	2.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	-	-	<b>5.00</b>	<b>3.00</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	3.00	3.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	16,745,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	16,745,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	16,745,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,745,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,745,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	16,745,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	16,745,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	16,745,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сум дахь сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Алтансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд аж ахуй нэгж, нөхөрлөлөөс авах авлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хоцроож мэдээлсэн талаар зөвлөмж өгч менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 05-наас 2021 оны 02 дүгээр сарын 09-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Булган сум дахь Сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Ойн санг хамгаалах, зүй зохистой ашиглаж нөхөн сэргээх, талбай тусгаарлалт хийх, мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох, иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн нөөц, баялгийг ашиглах хамгаалах талаар зөвлөгөө өгөх, зөрчлийг арилгуулах нь сум дундын ойн ангийн эрхэм зорилго оршино.” гэсэн зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Ойн менежмент

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ойн тухай хууль
- Бусад холбогдох хууль тогтоомж

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сум дахь сум дундын ойн ангийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймаг дахь төрийн аудитын газар 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 2414.03 мянган төгрөгийн 97 га талбай тусгаарлалтын авлага, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Булган аймаг дахь төрийн аудитын газар 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар хугацаа хоцроосон, огт мэдээлээгүй зэрэг зөрчил илрээгүй хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 18110.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 362.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сум дахь сум дундын ойн ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13198.9 мянган төгрөгөөр буюу 21 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ буюу үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	0		
Авлага	2414.03	0	2414.03
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	11495.8	10006.7	1489.1
Үндсэн хөрөнгө	88264.1	83998.8	4265.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>64806.4</b>	<b>51607.5</b>	<b>13198.9</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	64806.4	51607.5	13198.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>64806.4</b>	<b>51607.5</b>	<b>13198.9</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй. Төвлөрүүлсэн 1443.8 мянган төгрөг нь өөрийн үндсэн данснаас төвлөрүүлж аймгийн төсөвт шилжүүлжээ.

Авлага дансны үлдэгдэл 0.0 мянган төгрөг болж өмнөх оны авлагаас 2414.03 мянган төгрөгөөр буурсан нь авлага бууруулах ажил зохион байгуулан ажилласан. Авлага дансны үлдэгдэлд 2016-2019 онуудад үүссэн, он удаан жил болсон 2414.03 мянган төгрөгийг ААН, Нөхөрлөл, иргэнээс авах авлага байсныг 2020 онд барагдуулж дууссан байна.

Нийт 2414.03 мянган төгрөгийн авлагыг 2020 онд барагдуулж дууссан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10006.7 мянган төгрөг болж 1489.1 мянган төгрөгөөр буурсан нь оны эцсийн бичиг хэрэг, аж ахуйн материал зарлагдсан шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 10006.7 мянган төгрөгийн бараа материалаас ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Бараа материалын дансанд 2020 онд хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн болон харьяа байгууллагууд, захиалагч байгууллагад бараа материалын данснаас хөрөнгө шилжүүлээгүй бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 83998.8 мянган төгрөг болж 4265.3 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтгүй болсон 1 ширхэг компьютер, тавиур, вэб хуудас нийт 2085.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, дахин үнэлгээний 2170.0 мянган төгрөг нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгөөс акталсан 1685.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 400.0 мянган төгрөгийн вэб хуудас акталсан байна.

Өр төлбөрийн данс 0.0 үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 51607.5 мянган төгрөг болж өмнөх оноос 13198.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь дахин үнэлгээ болон акталсан хөрөнгөөс шалтгаалсан байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 40639.6 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос 59.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

Нийт зардал өмнөх оноос 675.8 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилт 16745.0 мянган төгрөгийг өмнөх оноос 4405.6 мянган буюу 0.6 хувиар буурсан байна. Дээд шатны байгууллагаас ордог санхүүжилт буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан болон залруулсан хөрөнгө байхгүй байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 86202.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 86202.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 41471.0 мянган төгрөгөөр бууруулж 44730.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчаас хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулаагүй үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 44730.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 32730.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 12000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 25072.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 18110.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 16745.0 мянган төгрөг нийт 62341.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 62341.7 мянган төгрөгийг зарцуулж 1443.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 45596.7 мянган төгрөг буюу нэмэлт санхүүжилт ороод 101.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны данснаас 1443.8 мянган төгрөг хэмнэсэн зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь үйл ажиллагааны санхүүжилтээс 1443.8 мянган төгрөг дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 12500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 32 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Талбай тусгаарлалт	12500.0	18110.5	5610.5	44
<b>Нийт дүн</b>	12500.0	18110.5	5610.5	44

#### Нэмэлт санхүүжилт

Булган аймгийн Булган сум дахь сум дундын ойн анги нь 2020 онд нэмэлт санхүүжилтээр 16745.0 мянган төгрөг санхүүжилт авсан аймгийн төсвөөс 10120.0 мянган төгрөг, 6625.0 мянган төгрөгийг дээд шатны байгууллагаас санхүүжилт авсан байна. Цар тахлын үеийн тусламж 10120.0 мянган төгрөгийг зорилтот бүлгийн иргэнд түлээ олгосон, 6625.0 мянган төгрөгийг талбай тусгаарлах буюу Ногоон төгөл аяны зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс хугацаа хоцроосон, мэдээлээгүй зөрчил илрээгүй. Шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар гарсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжгүй буюу алдаа зөрчилгүй, түүвэрт хамрагдсан байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5913.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5938.7 мянган төгрөгийн талбай тусгаарлалтын авлага үүсгээгүй зөрчилд 1 албан шаардлага, 62.4 мянган төгрөгийг даатгуулагчаас гарах шимтгэлийг цалингийн зардлаас гарах байсныг шимтгэлийн данснаас гаргасан. Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 62.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайлант онд үүссэн талбай тусгаарлалтын нийт төлбөрийг тайлант ондоо барагдуулж байх шаардлагатай. Авлагын барагдуулахгүйгээс дараа ондоо шилжиж авлагыг нэмэгдүүлэх, талбай тусгаарлалтын авлагыг авахгүй орхигдох зэрэг эрсдэл үүсэж байна. Дахин давтагдахгүй байхаар тухай онд авлага, өглөг үүсгэхгүй байх тал дээр арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Данс хоорондын данстай холбоотой

1.1. Илрүүлэлт: 62.4 мянган төгрөгийг даатгуулагчаас гарах шимтгэлийг цалингийн зардлаас гарах байсныг шимтгэлийн данснаас гаргасан.

1.2. Эрсдэл: НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын хавсралтын 1. цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зэрэг эдийн засгийн ангиллын дагуу төсвийн зардлыг удирдана.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Булган сум дахь сум дундын ойн ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			БУА-2021/24/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Булган суман дахь Сум дундын ойн анги</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Талбай тусгаарлалтын авлага	5913.6	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Б.Алтансүх Д.Дашдулам
2	Даатгуулагчаас гарах шимтгэлийг цалингийн зардлаас гаргах байсныг шимтгэлийн зардлаас гаргасан	62.4	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Б.Алтансүх Д.Дашдулам
<b>ДҮН</b>					

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР